



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ НӨХӨН БОЛОН ДАХИН
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН
ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

АУДИТЫН КОД: ХОА-2023/53-15-ШТА-ГА

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа

Утас: 7043-2545 Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Аудитор: У.Батчимэг

Утас: 7043-2545 Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4-5
БҮЛЭГ 1: ХУУЛИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ НАМ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭЖ НӨХӨН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.	6
БҮЛЭГ2: БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛСАН Ч СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЖ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГА БАЙНА..	7
ЗӨВЛӨМЖ:.....	8
ХАВСРАЛТУУД:.....	
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	9
САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:	10

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗД	Засаг дарга
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
МТА	Мэдээллийн технологийн ажилтан
МТБ	Мэдээллийн технологийн баг
ШТА	Шууд тайлагнах аудит
ГА	Гүйцэтгэлийн аудит

Хүснэгтийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдсан зардлын төсөв	6
Хүснэгт 2	Сонгуулийн зардлын гүйцэтгэл	7
Хүснэгт 3	Олгосон санхүүжилтийн гүйцэтгэл	8

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын ерөнхий аудиторын баталсан Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж зөвлөмж боловсруулан Үндэсний аудитын газар, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Нөхөн болон дахин сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх • Нөхөн болон дахин сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад аймгийн сонгуулийн хороо, Эрдэнэбүрэн сумын сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудыг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуултын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйл цуглуулан, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Тэргүүлэх аудитор Х.Болдбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн хэрэгжүүлж, аудитор Ц.Аззаяа, У.Батчимэг нар 2022 оны 07-р сарын 07-ноос 07-р сарын 19-нийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:	Аудитын тайланг Төрийн аудитын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан, аймгийн Сонгуулийн хороо холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, Үндэсний аудитын газарт нэгтгүүлэв.

БҮЛЭГ 1: ХУУЛИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ НАМ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭЖ НӨХӨН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

Аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс 34.6, Улсын бүртгэлийн хэлтэст 6.1, Цагдаагийн газарт 1.2, нийт 41.9 сая төгрөгийг хуваарилжээ.

- 1.1. Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр батлан, 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна. Тус хуулийн 10.6. "Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагуудын зардлыг Монгол Улсын Их Хурал баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ", 10.8. "Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5, 10.6, 10.7-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана", 10.11. "Аймаг, нийслэлийн Хурлын сонгуулийн хороодын тайланд тухайн орон нутаг дахь төрийн аудитын салбар байгууллагаар дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс 34.6, Улсын бүртгэлийн хэлтэст 6.1, Цагдаагийн газарт 1.2, нийт 41.9 сая төгрөгийг хуваарилжээ
- 1.2. Ховд аймгийн Сонгуулийн хороог аймгийн ИТХ-ын 2023 оны 03 сарын 30-ны өдрийн 11/15 тоот тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.
- 1.3. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд сонгуулийн хороог санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө байгуулахаар хуульчилсан тул нөхөн болон дахин сонгууль явуулах шаардлага үүссэн Булган, Мөнххайрхан, Эрдэнэбүрэн сумууд сонгуулийн хороог 2023 оны 4 дүгээр сард байгуулсан байна. Нөхөн сонгуульд аль нэг намаас нэр дэвшигч ирээгүй тул Булган, Мөнххайрхан сумууд нөхөн сонгуулийг хаах хүсэлтийг аймгийн Сонгуулийн хороонд ирүүлж сонгууль цуцлагдаж, Эрдэнэбүрэн суманд нөхөн сонгууль зохион байгуулагдсан байна.
- 1.4. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ны ажлын албанаас 3/172, 3/236 тоот албан бичгээр ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбарын дагуу холбогдох зардлуудыг Эрдэнэбүрэн сумын сонгуулийн хороонд хуваарилсан бөгөөд нийт төсвийн 40.8 хувь буюу 11.9 сая төгрөгийг хуваарилжээ.

Аудитын илрүүлэлт:

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар мөрийн хөтөлбөр, хандивын тайлангаа төрийн аудитын байгууллагад ирүүлж дүгнэлт гаргуулсан байхаар заасан байхад энэ шаардлагыг хангаагүй намуудыг бүртгэж сонгууль зохион байгуулсан нь Аймаг нийслэл сум дүүргийн сонгуулийн тухай хуулийн 27.4¹-д заасныг зөрчсөн байна. Мөн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт Эрдэнэбүрэн сумын ЗДТГ-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ны 2/84 тоот албан бичгээр сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлан ирээгүй тухай мэдэгдсэн байхад нам нэр дэвшигчдийг

¹ 27.4. Энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангаагүй нам, эвслийг бүртгэхээс татгалзана.

үндэслэлгүйгээр бүртгэсэн тухайн шатны сонгуулийн хороонд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага бичихээр шийдвэрлэв.

Аймгийн сонгуулийн хороо нь хэсгийн хороонд олгох төсвийг СЕХ-ноос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна.

1.6. Аймаг нийслэл, сум дүүргийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд 34.6 сая төгрөг хуваарилж гүйцэтгэлээр 32.6 сая төгрөгийн зардал санхүүжүүлж 2.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг сумын сонгуулийн хороонд хуваарилахдаа СЕХ-ны ажлын албанаас ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төсвийг нарийвчлан төлөвлөснөөр батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

1.7 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.1. “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ”, 10.2. “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ”, гэж заажээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст нөхөн сонгууль зохион байгуулахад 6.1 сая төгрөгийг баталж олгожээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын тушаалаар батлагдсан 4 хүний бүрэлдэхүүнтэй итгэмжлэгдсэн ажилтан, шуурхай багт 2 ажилтан тус тус Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн нөхөн сонгуульд ажилласан байна.

Сонгогчийн нэрсийн жагсаалт бүхий ирц бүртгэлтийн программын тоног төхөөрөмжийг хүлээн авах, хүлээлгэн өгөх ажлаар Улаанбаатар-Ховд чиглэлд 2 удаа явж ирсэн шатахууны зардалд 2.3 сая, томилолт 0.4 сая, бичиг хэрэг 0.3 сая, шуурхай багийн зардалд 0.5 сая, мөнгөн урамшуулалд 1.6 сая, татвар шимтгэлд 0.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хуваарилагдсан зардлын төсвийг хүснэгтээр харуулбал: Хүснэгт 1

		сая төгрөг			
д/д	Аймгийн нэр	УБ-ын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх болон хүргэх зардал	Техник хэрэгсэл тээвэрлэх болон сургалтын зардал	Нийт зардлын дүн
1	Ховд аймаг	1.8	0.8	3.5	6.1
Нийт дүн		1.8	0.8	3.5	6.1

Аймгийн Цагдаагийн газарт 3 сумын нөхөн сонгуулийн хамгаалалтын зардал 1.2 сая төгрөгийг хуваарилсан байна.

1.8 Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.3. “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан


зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заажээ.

1.9 Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд 3 сумын хамгаалалтын зардал 1.2 сая төгрөгийн төсөв хуваарилагдсаныг 2 суманд нөхөн сонгууль зохион байгуулагдаагүйтэй холбоотой 0.8 сая төгрөгийг буцаан шилжүүлж 0.4 сая төгрөгийг 4 ажилтны хоол, шуудан холбоо, шатахууны зардалд тус тус зарцуулсан байна.

БҮЛЭГ 2: БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛСАН Ч СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЖ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГА БАЙНА.

2.1. Сумын ИТХ-ын нөхөн сонгуулийг зохион байгуулах зардалд 39.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

2.1. Эрдэнэбүрэн сумын Баянгол багийн орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгуульд аймаг, сумын 2 сонгуулийн хороо, 1 хэсгийн хороонд нийт 35 гишүүд, мэдээлэл технологийн ажилтан ажиллаж , нийт 285 сонгогч бүртгэгдсэнээс 134 сонгогч саналаа өгч 47.0 хувийн ирцтэй оролцжээ.



2.2 Аймаг нийслэл, сум дүүргийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор улсын төсвөөс аймгийн сонгуулийн хороонд 34.6 сая төгрөгийн санхүүжилт олгож гүйцэтгэлээр 32.6 сая төгрөг зарцуулж 2.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: Хүснэгт 2

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	150,000	150,000	-
2	Үнэмлэх хэвлэх зардал	150,000	150,000	-
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	520,000	498,000	22,000
4	МТБ-ийн сургалтын зардал	80,000	80,000	-
5	Бичиг хэргийн зардал	1,050,000	550,000	500,000
6	Шуудан холбооны зардал	1,200,000	600,000	600,000

	Унааны зардал	1,470,000	1,470,000	-
7	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	300,000	300,000	-
8	Сурталчилгааны зардал	500,000	500,000	-
9	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолт	8,568,000	8,467,860	100,140
10	Мэдээ дамжуулах, шуурхай ажлын МТБ-ийн зардал	310,000	-	310,000
11	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	120,000	120,000	-
12	Унаа /туршилт болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/	105,000	105,000	-
13	Томилолтын зардал	3,384,000	3,384,000	-
14	Болзошгүй зардал	500,000		500,000
15	Аймаг, сум, хэсгийн хорооны гишүүдийн урамшуулал хоолны зардал	13,800,000	13,800,000	-
16	МТТ-ийн багийн гишүүн, санал авах байрны даамлын урамшуулал, хоолны зардал	2,400,000	2,400,000	-
	НИЙТ ДҮН	34,607,000	32,574,860	2,032,140

Аудитын илрүүлэлт

- Батлагдсан төсвийг хуваарилан зарцуулсан ч хүнс авах, хоолны тооцоо хийх зэрэг 0.7 сая төгрөгийн үр ашиггүй үрэлсэн зардал гаргасан байна.
- Улсын төсвөөс нийт 41.1 сая төгрөг хуваарилж гүйцэтгэлээр 39.1 сая төгрөгийг зарцуулж аймаг сумын сонгуулийн хороо, хэсгийн хороо байгуулан 35 төрийн албан хаагч ажиллуулж 134 сонгогчтой сонгууль зохион байгуулсан байна. Цаашид нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зайлшгүй шаардлагыг үнэлсний үндсэнд бий болох үр нөлөө, эдийн засгийн үр өгөөж, ард иргэдэд үзүүлэх үр шимийг тооцож сонгууль зохион байгуулах шаардлагатай байна.

2.3 Аймаг сумын сонгуулийн хороо нь СЕХ-ноос өгсөн аргачлал, зөвлөмжийн дагуу зардлыг санхүүжүүлж авлага, өр төлбөр үүсгэхгүйгээр ажиллажээ. Нийт олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал: Хүснэгт 3

д/д	Сонгуулийн хэсгийн хорооны нэрс	Хэсгийн хорооны тоо	Гишүүд МТАжилтан	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Зөрүү
1	Аймгийн Сонгуулийн хороо		15	22.7	20.7	2
2	Эрдэнэбүрэн сум	1	12	11.9	11.9	
3	Улсын бүртгэлийн хэлтэс		4	6.1	6.1	
4	Цагдаагийн газар		4	1.2	0.4	0.8
	НИЙТ дүн	1	35	41.9	39.1	2.8

Эрдэнэбүрэн сумын сонгуулийн хороо нь хуваарилагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

2.4. Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хуралдааны 2023 оны 10/04 дүгээр тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй сумын сонгуулийн хороо байгуулагдсан байна.

Сумын сонгуулийн хорооны 2023 оны 03 дугаар тогтоолоор Баянгол багийн нөхөн сонгууль явагдах хэсгийн хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй, мэдээлэл технологийн даамал, иргэний бүртгэлийн ажилтан, цагдаагийн ажилтан зэрэг нийт 15 төрийн албан хаагч томилогдон ажиллажээ.

2.5 Томилолт унааны зардлаас сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, мэдээлэл технологийн даамал, жолооч нарт Ховд аймгаас сонгуулийн материал авах, дүн мэдээ тушаахад томилолт 0.6 сая, унааны зардалд бензиний зөвшөөрлийн бичгээр 0.2 сая, урамшуулал хоолны зардлаас сонгуулийн хорооны даргад аймгийн Сонгуулийн хорооны тогтоолоор 0.6 сая, СЕХ-ноос ирүүлсэн албан бичиг, төсөв зарцуулах тайлбар, захирамжийг үндэслэн 14 хүнд 8.7 сая төгрөгийн урамшууллыг тус тус олгосон байна.

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн 2 зөрчил илэрч 0.7 сая төгрөгийн 1 зөвлөмж, 1 албан шаардлага бичлээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

- **ХУУЛИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ НАМ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭЖ НӨХӨН СОНГУУЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.**
- **БАТЛАГДСАН ТӨСВИЙН ХҮРЭЭНД ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛСАН Ч СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЖ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ШААРДЛАГА БАЙНА.**

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Сонгуулийн хорооны дарга Б.Сандагсүрэнд зөвлөх нь:

1. Аймгийн Сонгуулийн хороо, сумын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж ажиллах.

Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 12 өдөр

Дугаар A/18

Ховд

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 1.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтууд, Монгол улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар "эрх үүрэг, шилжүүлэх тухай" дугаар тушаал, 2021 оны А/69 дугаар тушаал, 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1 Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг аймгийн Үндэсний аудитын газар, аймгийн Сонгуулийн хороо хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон ажиллахыг аудитын менежер /А.Цэцэгсүрэн/-д, аудитор /Ц.Аззаяа/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 56/А 2170425

Ховд

ХОА-2023/53-15-ШТА-ГА

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргах аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар мөрийн хөтөлбөр, хандивын тайлангаа төрийн аудитын байгууллагад ирүүлж дүгнэлт гаргуулсан байхаар заасан байхад энэ шаардлагыг хангаагүй намуудыг бүртгэж сонгууль зохион байгуулсан, мөн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт Эрдэнэбүрэн сумын ЗДТГ-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ны 2/84 тоот албан бичгээр сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлан ирээгүй тухай мэдэгдсэн байхад нам, нэр дэвшигчдийг үндэслэлгүйгээр бүртгэсэн зөрчил илэрлээ..

Энэ нь Аймаг нийслэл сум дүүргийн сонгуулийн тухай хуулийн 27.3.4. "сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангасан тухай төрийн аудитын байгууллагын дүгнэлт гарч хавсаргасан"; 27.4 "Энэ хуулийн 27.3-т заасан шаардлагыг хангаагүй нам, эвслийг бүртгэхээс татгалзана" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нам, нэр дэвшигчдийг бүртгэх үйл ажиллагааг хууль журамд заасан шаардлагыг хангасан тохиолдолд бүртгэх, илэрсэн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх.
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 09 сарын 15-ний дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Сонгуулийн хорооны дарга Б.Сандагсүрэн, Эрдэнэбүрэн сумын Сонгуулийн хорооны дарга Ч.Цэнд-Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

АУДИТОР  Ц.АЗЗАЯА

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Орон нутгийн 2023 оны нөхөн болон дахин сонгууль зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргах

Аудитын код: ХОА-2023/53-15-ШТА-ГА

Байгууллагын нэр: Аймгийн Сонгуулийн хороо

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мян.төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал	Гаргасан шийдвэр
А	1	2	3	5	6	7	8
1	• Нөхөн болон дахин сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх	2	Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар мөрийн хөтөлбөр, хандивын тайлангаа төрийн аудитын байгууллагад ирүүлж дүгнэлт гаргуулсан байхаар заасан байхад энэ шаардлагыг хангаагүй нэмүүдэг бүртгэж сонгууль зохион байгуулсан зөрчил гаргасан байна. Энэ нь Аймаг нийслэл сум дүүргийн сонгуулийн тухай хуулийн 27.4 -д заасныг зөрчсөн байна. Мөн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт Эрдэнэбүрэн сумын ЗДТГ-ын 2023 оны 05 дугаар сарын 04-ны 2/84 тоот албан бичгээр сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлан ирээгүй тухай мэдэгдсэн байхад нам нэр дэвшигчдийг үндэслэлгүйгээр бүртгэсэн.	-	Албан шаардлага		
2	• Нөхөн болон дахин сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг арвиалан хэмнэлттэй зарцуулсан эсэх	3	Батлагдсан төсвийг хуваарилан зарцуулсан ч хүнс авах, хоолны тооцоо хийх зэрэг 0.7 сая төгрөгийн үр ашгийг үрэлгэн зардал гаргасан байна.	737.6	Зөвлөмж		
Нийт дүн				737.6			

Бэлтгэсэн: Аудитор

Ц.Азаяа

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

А.Цэцэгсүрэн

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор

Х.Болдбаатар

Танилцаж зөвшөөрсөн:

СХ-ны дарга

Нягтлан бодогч

В.Сандагсүрэн

В.Даваадорж



**ХОВД АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

84000 Ховд, Ховд аймаг

Утас: 7043-2864 Факс: 976-7043-2864

2023.07.21 № 08

танай _____-ны № _____-т

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Х.БОЛДБААТАР
ТАНАА**

2023 оны нөхөн сонгуулийн тайлангийн
аудитын төсөлд өгөх санал, тайлбар байхгүй
болно.

АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ДАРГА  Б.САНДАГСҮРЭН

